



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Б.БАТТӨМӨР ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2023.09.15 № ХЗТ/1990  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Ирээдүйн өв сангийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Сангийн яамнаас бэлтгэж ирүүлснийг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцахыг хүсье.

Хавсралт 4 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

000235020243



## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn  
Вэбсайт: www.mof.gov.mn

2023.09.14 № 01/6864

танай 2023.08.30-ны № ХЭГ/1897-Т

### МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА


Танаас ирүүлсэн “Асуулгын хариу бэлтгүүлэх тухай” 2023 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн ХЭГ/1897 тоот албан бичигтэй танилцлаа.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрөөс 2023 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 25 тоот албан бичгээр Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд ирүүлсэн Ирээдүйн өв сангийн тухай хуулийн хэрэгжилтийн талаарх асуулгын хариуг гарган хавсралтаар хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт: 3 хуудастай.

Хүндэтгэсэн,



Б.ЖАВХЛАН

9761001985

Сангийн сайдын 2023 оны 9 дүгээр сарын 27 -ны өдрийн  
.....01/6864..... тоотын хавсралт



## **ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР АСУУЛГЫН ХАРИУ**

### **1. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн талаар**

Монгол Улсад олон улсын жишигт нийцсэн баялгийн сангийн тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр Ирээдүйн өв сангийн тухай хууль 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдөр батлагдаж, 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Ирээдүйн өв сангийн тухай хууль 7 бүлэг, 33 зүйлтэй бөгөөд сангийн орлого, зарлага, сангийн хөрөнгийн удирдлага, түүний зарчим, хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч корпораци, түүний үйл ажиллагаа, сангийн засаглал, тайлагнал, ил тод байдал, хяналт зэрэг үйл ажиллагааг энэхүү хуулиар зохицуулна.

Тус хуулийн төслийг Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачилан Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд Сангийн яам нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газартай хамтран боловсруулсан болно. Хуулийн төслийг боловсруулахдаа баялаг ихтэй улс, орнуудын уул уурхайн орлогын менежмент болон олон улсын баялгийн сангуудын сайн туршлага, тухайлбал, Норвегийн Глобал тэтгэврийн сангийн хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаа, зохицуулалтыг жишиг болгосон. Түүнчлэн баялгийн сангуудын Олон улсын форумаас гаргасан нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн Сантьяго зарчмын 24 үзүүлэлттэй нийцүүлэн боловсруулж, батлуулсан.

### **2. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар**

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрөөс ирүүлсэн 2023 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 25 тоот албан бичигт дурдсан асуулгын хариуг дараах байдлаар хүргүүлж байна. Үүнд:

1. Ирээдүйн өв санд Хүний хөгжил сангаас шилжиж ирсэн өр, төлбөрийг 2019 онд бүрэн барагдуулж дуусгаснаар хуримтлал үүсч эхэлсэн бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар Ирээдүйн өв санд нийт 2,618.1 тэрбум төгрөгийн хуримтлал үүсээд байна. Ирээдүйн өв санд хуримтлал үүсч эхлэхтэй зэрэгцүүлэн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх институцийг байгуулах, үйл ажиллагааг эхлүүлэх, хөрөнгийн удирдлагын Мандатыг боловсруулж, батлуулах зэрэг арга хэмжээг авч ажилласан.

Сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч хуулийн этгээд байгуулсан ч түүгээр дамжуулан сангийн хөрөнгийг гадаадын хөрөнгийн зах зээлд удирдах ажил удаашралтай байна. Учир нь дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас манай улсын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр 51 дүгээр зүйлийг "Ирээдүйн өв сангийн хөрөнгийг 2025 он хүртэл Засгийн газрын гадаад өрийн дарамтыг харгалзан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төрийн сангийн нэгдсэн дансыг удирдах, мөнгөн хөрөнгийн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд хуримтлуулна" гэж өөрчилсөн. Өөрөөр хэлбэл цар тахлын нөлөөллөөр бий болсон эдийн засгийн хүндрэлийн үед Монгол Улсын гадаад валютын нөөцийг тогтвортой хадгалах, гадаад зээл, үнэт цаасны төлбөрийг хүлээсэн үүргийн хүрээнд



хугацаанд нь барагдуулах, олон улсын санхүүгийн зах зээл дээрх тодорхойгүй нөхцөл байдал, эрсдэлээс хамгаалах зорилгоор хойшлуулах, төгрөгийн ханшны огцом хэлбэлзлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн, 2025 оноос эхлэн Ирээдүйн өв сангийн хөрөнгийн удирдлагыг олон улсын санхүүгийн зах зээлд хэрэгжүүлэх юм.

2. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 18.1, 18.7 дахь хэсэгт тус тус заасныг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газрын 2019 оны 303 дугаар тогтоолоор Ирээдүйн өв сан корпорацийг байгуулж, түүний дүрмийг баталсан. Дээр дурдсан Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд 2025 он хүртэл хугацаанд корпораци бие даан тогтвортой үйл ажиллагаа явуулах бүтэц, чадамжтай болох хүртэл сангийн хөрөнгийн удирдлагыг олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлэхээр тогтоосон байна.

Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Сангийн яамнаас сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлж эхлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажилласан ба i) Гадаадын мэргэшсэн банк санхүүгийн байгууллагаар хөрөнгийг удирдуулах, ii) Гэрээний үндсэн дээр сангийн хөрөнгийг Монголбанкаар дамжуулан удирдах, iii) Дэлхийн банкны нөөцийн удирдлагын хөтөлбөрт хамрагдах зэрэг арга замуудыг судалж, санал боловсруулсан.

Эдгээр ажлын хүрээнд 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 8-2/828 тоот албан бичгээр хөрөнгө оруулалтын компаниудад сангийн хөрөнгийг удирдуулах талаар санал авах бичиг (Request for Proposal/RFP) илгээсэн. Тухайлбал, удирдаж буй хөрөнгийн хэмжээгээрээ эхний 40-д багтах компаниуд руу холбоо тогтоон сангийн хөрөнгийг удирдуулах талаар санал авах бичгийг илгээсэн. Нийт 11 компаниас хариу, санал ирүүлсэн бөгөөд 8 компани нь манай илгээсэн саналтай нийцэхгүй буюу пассив хөрөнгө оруулалт хийдэггүй тул татгалзсан хариу ирүүлсэн бол 3 компани сангийн хөрөнгийг удирдах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн.

Түүнчлэн, Сангийн хөрөнгийг Монголбанкаар удирдуулах чиглэлээр 2020 оны 01 дүгээр сарын 07-ний өдрийн 8-2/74 тоот албан бичгээр хөрөнгийн удирдлагын хүрээнд чадавхи, хүний нөөц, дэд бүтцийг ашиглах, хамтран ажиллах, холбогдох гэрээний үндсэн дээр сангийн хөрөнгийг удирдуулах санал тавьсан болно. Монголбанк зөвхөн хөрөнгийн удирдлагыг “Санхүүгийн зуучлалын гэрээ”-ний хүрээнд хэрэгжүүлэхээр гэрээний төслийг боловсруулж, Монголбанкнаас санал авсан. Хөрөнгө удирдсаны шимтгэлийг Монголбанкны зүгээс Дэлхийн банкны нөөцийн удирдлагын хөтөлбөр буюу RAMP-н шимтгэлтэй ижил хувиар тооцох санал гаргаж байсан ба Сангийн яамнаас шимтгэлийг хамгийн бага түвшинд буюу зөвхөн төлбөр тооцоо хийхтэй холбогдон гарах зардлаар хязгаарлах саналыг тавьсан.

3. Ирээдүйн өв сангийн тухай хуульд сангийн хөрөнгийн удирдлагыг хараат бус, бие даасан хуулийн этгээд болох Ирээдүйн өв сан корпорациар удирдуулахаар заасан бөгөөд тус корпораци нь Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 18.2-т заасны дагуу хөрөнгө оруулах шийдвэрийг мандат, хөрөнгө оруулалтын стратегийн хүрээнд гаргахаар тогтоосон болно. Сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлж эхлэх хүрээнд хөрөнгийн удирдлагын гол баримт бичиг болох “Хөрөнгийн удирдлагын мандат”-ыг Сангийн сайдын 2020 оны 10 дугаар тушаалаар баталсан боловч Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлттэй холбоотой хэрэгжилт хойшлогдсон болно.

}  
}

}  
}

}  
}

4. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлд сангийн хөрөнгийг удирдахад баримтлах зарчмыг тогтоож, 6 дугаар зүйлд уг зарчмыг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлж өгсөн болно. Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор хуулийн 5.1.1, 5.1.3, 5.1.4, 6.1.1 дэх заалтуудын хөрөнгийн удирдлага хэрэгжих шаардлага үүсээгүй болно.

Харин хуулийн 5.1.2-т сан ил тод байх гэж заасан ба төрөөс мэдээллийн ил тод байдлыг хангах хүрээнд хэрэгжүүлж буй шилэн данс цахим хаягаар дамжуулан Ирээдүйн өв сангийн төсвийн гүйцэтгэлийг сар бүр, сангийн санхүүгийн тайланг хагас жилээр гарган, байршуулж олон нийтэд мэдээллийг ил тод хүргэж байна. Харин корпорацийн хэрэгжүүлэх мэдээлэл түгээх ажил корпорацийн үйл ажиллагаа жигдэрснээр хэрэгжих боломжтой байна.

5. Ирээдүйн өв сангийн тухай хуульд заасан сангийн орлогыг төвлөрүүлэх, хуримтлал үүсгэх чиглэлээр хуулийн хэрэгжилт сайн байгаа боловч дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахал, Орос-Украины зэвсэгт мөргөлдөөний улмаас манай улсад бий болсон эдийн засгийн хүндрэлийн улмаас хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч корпорацийн үйл ажиллагаатай холбоотой хэрэгжилт удаашралтай байна. Цаашид Ирээдүйн өв санг Монгол Улсын Үндсэн хуулийн зургадугаар зүйлийн хоёрт заасантай нийцүүлэн байгалийн баялгаас олох орлогыг Үндэсний баялгийн сангаар дамжуулан одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг тэгш, шударга хүртээхэд чиглүүлэн ажилна.